



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/168

Улаанбаатар хот

Төхижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх,
хог хаягдлыг бууруулах ажлыг эрчимжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны “Журам батлах тухай” 63 дугаар тогтоол, 2012 оны “Журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 61 дүгээр тогтоол, Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.6.3 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 10.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Төхижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчлан хамгаалах, хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах, цэвэрлэгээний менежментийг сайжруулах, нийгмийн хариуцлагыг дээшлүүлэх, хуулиар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, худалдаа үйлчилгээний газар, үйлдвэр, иргэдийн эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50м хүртэлх газрын өнгө үзэмжийг нэмэгдүүлэх ажлыг 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс 08 дугаар сарын 24-ний өдөр хүртэл дүүргийн хэмжээнд зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төхижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, арчлан хамгаалах, хог хаягдал, орчны бохирдлыг бууруулах, цэвэрлэгээний менежментийг сайжруулах ажилд идэвх санаачилгатай оролцож, зохион байгуулсан ажлын тайланг 2025 оны 08 дугаар сарын 26-ны өдөр Ажлын хэсэгт хүргүүлэхийг аж ахуйн нэгж байгууллагын дарга, захирал, эрхлэгч нарт үүрэг болгосугай.


3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлан мэдээг цаг хугацаанд нь нэгтгэн холбогдох газарт хүргүүлэхийг Ажлын хэсэг (Г.Дагвадорж)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны дугаар сарын-ны өдрийн
..... дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх,
хог хаягдлыг бууруулах ажлыг зохион байгуулах
Ажлын хэсэг

Дарга: Г.Дагвадорж

Дүүргийн Менежер

Гишүүд: Ё.Гэрэлцэцэг

Засаг даргын Тамгын газрын
Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн
Ахлах мэргэжилтэн
1 дүгээр хорооны Засаг дарга
2 дугаар хорооны Засаг дарга

Н.Нямзав
Б.Батзориг

Нарийн бичгийн дарга:

Б.Дүүрэнжаргал

Засаг даргын Тамгын газрын
Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн
Тохижилт, хог хаягдал, орчны бохирдол
хариуцсан мэргэжилтэн

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2025 оны дугаар сарын-ны өдрийн
..... дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

ТОХИЖИЛТ, НОГООН БАЙГУУЛАМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ,
ХОГ ХАЯГДЛЫГ БУУРУУЛАХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
1.	Зохион байгуулах ажлын төлөвлөгөө боловсруулах, аж ахуйн нэгж байгууллага, хороодод хүргэх.	2025.07.25-28	ЗДТГ
2.	Их цэвэрлэгээ, шарилж устгах ажлыг зохион байгуулах, авто зам дагуух хог хаягдлыг цэвэрлэж, тээвэрлэх	2025.07.28-07.31	ЗДТГ, Хороод, Багахангай тохижилт, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ ААНБ, Айл өрх
3.	Нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн тохижилт, ногоон байгууламжийг арчилж хамгаалах, хайс, хашлага, сандал, хогийн сав, шон г.м угааж цэвэрлэх, будаж өнгө үзэмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	2025.07.25-08.24	Багахангай тохижилт, Багахангай гэрэлтүүлэг, ногоон байгууламж ОНӨААТҮГ
4.	ААНБ өөрийн эзэмшлийн гадна фасад, хаяг, хашааны өнгө үзэмжийг шинэчлэн засварлаж, тогтмол угааж арчлах	2025.07.25-08.24	Бүх аж ахуйн нэгж, байгууллагууд
5.	Өөрийн хөрөнгө, санал, санаачилгаар ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, гадна талбайг тохижуулах	2025.07.25-08.24	Бүх аж ахуйн нэгж, байгууллагууд
6.	Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах, зохион байгуулсан ажлын явцын илтгэх хуудсыг Ажлын хэсэгт бэлтгэн хүргэх	2025.07.31, 2025.08.07, 2025.08.14, 2025.08.21	Ажлын хэсэг, ААНБ
7.	Тохижилт, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, хог хаягдлыг ангилан ялгах чиглэлээр зохион байгуулсан ажлыг олон нийтийг уриалсан, иргэдийг татан оролцуулсан зөв хандлага, мэдээ мэдээлэл олгосон, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулан сурталчлах	2025.07.29, 2025.08.04, 2025.08.11, 2025.08.24	ЗДТГ Бүх аж ахуйн нэгж, байгууллагууд
8.	Зохион байгуулсан ажлын	2025.08.25	Бүх аж ахуйн нэгж,

	төлөвлөгөөний биелэлт, тайланг фото зургаар баталгаажуулан Ажлын хэсэгт хүргэх		байгууллагууд
--	--	--	---------------